

ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХАРИУЦАН ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТУСГАГДСАН
ЗААЛТУУДЫН 2022 ОНЫ ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН /10 арга хэмжээ/

Үндэсний геологийн алба

2022 он

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
№	ЗГҮАХ-т тусгагдсан, зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Хамтрагч	Төсөв (сая төгрөг)	Хүрэх түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр)		Хэрэгжилтийн хувь
								2022 ОН		
								Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭР										
1	3.2.3. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх геологи, судалгааны ажлыг эрчимжүүлэх, эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлэх	1	1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын хэмжээг нэмэгдүүлэх, нутаг дэвсгэрийн 47%-ийг хамруулна.	2020-2024	УУХҮЯ	ҮГА	Нийт хөрөнгө: 38.826.8 2022 төсөв: 11,782.9	Нутаг дэвсгэрийн 45%-ийг хамруулах, ашигт малтмалын хэтийн төлөвтэй 18 талбай ялгана.	- Тайлан хамгаалсан төслүүд: 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын Норовлин-50, Сүүжийн говь-50, Чулуун хороот-50, Шүтээн улаан уул-50, Цайлангийн нуруу-50, Модот толгой-50, Бүрхтэй уул-50, Галбын говь-50 төслүүдийн үр дүнгийн тайланг 2022 оны 05 дугаар сарын 31, 06 дугаар сарын 02-ны өдрүүдэд Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн хурлаар оруулан хэлэлцүүлж батлуулснаар 29380 км2 талбай буюу Монгол орны нутаг дэвсгэрийн 1,87 %-ийг хамруулж, давхарга зүйн 85 формац, гүний болон бага гүний 34 бүрдлийг ялган зурагласан. Ашигт малтмалын хувьд Төмөр-вольфрамитын-1, Цагаан туглаганы-1, Хайлуур жонш-1, Нүүрсний-1, Шохойн чулууны-2, Давсны-3 нийт 8 орд, Алтны 9, Зэс-алтны 2, Алт-цагаан тугалга-мышьякын 1, Зэсийн-5, Зэс-төмрийн 2, Молибден-1, Төмөр-3, Хром-никелийн-1, Иттри-циркон 1,	90

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
									Хар тугалга-цайрын 5, Висмутын 1, Хайлуур жоншны-1, Нүүрсний 3, Шохойн чулууны 3, Шаврын 3, Элс-хайрганы 1, Элсний 2, Гоёл чимэглэлийн чулуу-1, Өнгөлгөөний чулуу-1, Цеолит-1, Гипсийн 2 нийт 49 илрэлийг тогтоож Р зэргээр үнэлгээ өгсөн. Мөн Эрдэсжсэн цэг-253, Цэгэн гажил-1485, Геохимийн сарнилын хүрээ-774, Шлихийн сарнилын хүрээ-484-ыг олж, тогтоож Монгол улсын Геологи, эрдэс баялгийн мэдээллийн санд бүртгүүлэх ажил хийгдэж байна. -Шинээр хэрэгжих төслүүд: 2022 онд 1:50000-ны масштабын геологийн зураглал ерөнхий эрлийн ажлын 6 төслийг шинээр эхлүүлэхээр Засгийн газрын мөрийн хөтөлбөр, Алсын хараа 2050 болон үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, бүс нутгийн хөгжил, эдийн засгийн өсөлтийг хангах эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлэх зорилгод нийцүүлэн геологийн тогтцыг нарийвчлан судлах металлогений муж, бүс, голлох хүдрийн дүүрэг, зангилаануудыг судалж орд, илрэлүүдийг нэн тэргүүнд нээн илрүүлэх боломж, зарчмыг баримталж, 16983 км2 талбайд Баянзүрх уул-50, Ханхар уул-50, Үүрэг нуур-50, Мөст уул-50, Ямбат уул-50, Овоот шар-50 төслүүдийн хэрэгжүүлэхээр геологийн даалгаврыг боловсруулж, төсөл гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, геологийн судалгааны ажлыг 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдөр зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулж, төслүүдийн ажлыг хэлүүлсэн. -Тайлантай төслүүд: 1:50000-ны масштабын геологийн зураглал ерөнхий эрлийн ажлын Халзан овоо-50, Хулд-50, Оорцог уул-50, Дөч гол-50, Өндөр ширээт-50, Хайрхан овоо-50, Ширээт уул-50, Алаг баян-50 төслүүдийн 2022 оны үр	

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
									дүнгийн тайлан боловсруулалтын ажил 51,8%, нийт төсвийн гүйцэтгэл 94.5%-тай хэрэгжиж байна. -Үргэлжлэн хэрэгжиж буй төслүүд: 1:50000-ны масштабын геологийн зураглал ерөнхий эрлийн ажлын Овоот толгой-50, Загал уул-50, Үнэгт уул-50, Их хараат уул-50, Цэцэрлэг-50, Их элээт уул-50, Уушгийн улаан-50, Торлог уул-50, Улаангом-50, Их бэрхийн уул-50, Гилбэнт уул -50, Зангат-50, Цагаан-Овоо-50, Идэртийн нуруу-50, Борзонгийн говь-50, Ямаат уул-50, Буйлст хүрэн уул-50, Бөөн хөх уул-50, Хар хайрхан-50 төслүүд 2022 оны завсрын суурин боловсруулалт болон хээрийн үйлдвэрлэлийн ажлаар голлон доорх ажлуудыг гүйцэтгэж байна. Үүнд: 1. Маршрутын судалгаагаар бүрдүүлсэн анхдагч материалыг дахин шалгаж, литологи-структурын зурагтай нягтлан тулгах, 2. Агаар, сансрын зургийн тайлалт хийх, шаардлагатай геологийн судалгааны баримт, мэдээлэл бүрдүүлэх, 3. Геофизик болон Лабораторийн үр дүнг боловсруулах, зураг зохиох, тайлалт хийх мөн үр дүнгээр шалган холбох маршрут, уулын ажил төлөвлөх, 4. 2022 оны судалгааны ажлын төлөвлөгөө гаргаж, арга аргачлалыг боловсруулах, ажлын төсөл, төсөв зохиох, 5. 2022 оны хээрийн үйлдвэрлэлийн ажлаар зураглал, эрэл, уулын нэвтрэлт шурф, суваг нэвтрэлт, геофизикийн хэмжилт судалгаа, геоэкологи, гидрогеологи, геохимийн сорьцлолт, хээрийн ажиглалт судалгааны ажлуудыг гүйцэтгэж байна.	
		2	1:25000-ны масштабын	2022-2024	УУХҮЯ	ҮГА	Нийт хөрөнгө: 17,000.0	Нутаг дэвсгэрийн	1:25000-ны масштабын нарийвчилсан геологийн зураглалын ажлыг хэрэгжүүлэхэд	90%

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
			нарийвчилсан геологийн зураглалын ажлыг эхлэх, нутаг дэвсгэрийн 0,15-ийг хамруулна.				2022 төсөв: -	0,05%-д судалгааны ажил эхэлнэ.	зайлшгүй шаардагдах баримт бичгийг боловсруулах, батлуулах ажлын хүрээнд “1:25000-ны масштабын нарийвчилсан геологийн зураглалын ажил гүйцэтгэх заавар, түүнд тавигдах шаардлага” зааврын төсөлд салбарын мэргэжлийн холбоод, эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтдээс саналыг авч, холбогдох зардлыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн Сайдын 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/87 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох” журмын 3 дугаар зүйлийн 2.18 заалтын дагуу геологийн судалгааны ажлын аргачлал хяналтын зардлаас санхүүжүүлэхээр төлөвлөгөөний төсөлд тусган батлуулахаар ажиллаж байна.	
		3	Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг нэгтгэж дуусах, нутаг дэвсгэрийн 100%-ийг	2021-2023	УУХҮЯ	ҮГА	Нийт хөрөнгө: 3,515.2 2022 төсөв: 1,778.7	L, M, /N/ хавтгайд буюу нутаг дэвсгэрийн 80%-ийг хамруулна.	2019-2022 онуудад хэрэгжих УГЗ-200-L лист нэгтгэл төслийн хэмжээнд хийгдэх хээрийн бүх төрлийн судалгааны ажлууд төлөвлөгөөт хугацаандаа явагдаж дууссан. 2022 оны эцсийн үр дүнгийн тайлан боловсруулалтын ажлаар: - L-46-ын 27 хавтгайн иж бүрдэл зургийн нийт 108 ш санг шалган, нэгтгэл ажлыг хийж дууссан. - L-46 хавтгайн Геологи, Ашигт малтмалын зургийн нэгтгэл боловсруулалтын ажил 40%, - L-46 хавтгайн Дөрөвдөгчийн геологийн зургийн нэгтгэлийн ажил 80%, - L-46 хавтгайн Экологи геологийн зургийн нэгтгэлийн ажил 70%-ийн гүйцэтгэлтэйгээр явагдаж байна. Нэгтгэл хийгдсэн бүх зургуудыг хэвлэгдэж, хянагдсан. Төслийн нийт төсвийн гүйцэтгэл 85,2%-тай хэрэгжиж байна. 2020-2023 онд хэрэгжих УГЗ-200-M лист нэгтгэл төсөл 2022 оны 05 дугаар сарын 31-	90%

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
									ний байдлаар доорх ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: - М-45, М-46, М-47 хавтгайнуудын хэмжээнд томсгосон байдлаар 56 листийн 1:200 000, 1:500 000 масштабын топо суурь зургуудыг боловсруулан бэлтгэсэн. - 2021 онд хээрийн судалгаагаар бүрдүүлсэн анхдагч материалыг дахин нягтлан, шалгаж М-45, М-46, М-47 хавтгайнуудын хэмжээнд томсгосон байдлаар 56 листийн баримт материалын зургийг ажлын хувилбараар зохиосон. - М-47 хавтгайн хэмжээнд томсгосон байдлаар 15 хавтгайн геологийн зургийг дагалдах мэдээллийн сангийн хамт шинэчлэн зохиож дуусгасан. - М-45 хавтгайн томсгосон байдлаар 5 листийн дөрөвдөгчийн хурдсын зураг (геоморфологи, таних тэмдэг), экологи-геологи (аюулгүй үнэлгээ, байгалийн дурсгалт газар, таних тэмдэг)-ийн зургуудыг зохиож, дагалдах мэдээллийн сангийн хамт редакцын гишүүдээр хяналт, засвар хийлгэхэд бэлэн болгож, хэвлэж бэлтгэсэн. - М-46 хавтгайн томсгосон байдлаар 22 листийн дөрөвдөгчийн хурдсын зураг (геоморфологи, таних тэмдэг), экологи-геологи (аюулгүй үнэлгээ, байгалийн дурсгалт газар, таних тэмдэг)-ийн зургуудыг зохиож, дагалдах мэдээллийн сангийн хамт редакцын гишүүдээр хяналт, засвар хийлгэхэд бэлэн болгож, хэвлэж бэлтгэсэн. - М-47 хавтгайн томсгосон байдлаар 29 листийн дөрөвдөгчийн хурдсын зураг (геоморфологи, таних тэмдэг)-ийг зохиож, дагалдах мэдээллийн сангийн хамт редакцын гишүүдээр хяналт хийлгэхэд бэлэн болгосон.	

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
									- 2022 оны 05 дугаар сард хээрийн үйлдвэрлэлийн ажил эхэлж, 100 тууш км шалгах маршрут болон геохими, петрографи, үнэмлэхүй насны 205 цэгийн сорьцлолтын ажил гүйцэтгэсэн. Төслийн нийт төсвийн гүйцэтгэл 59,6%-тай хэрэгжиж байна. /2020-2023/.	
		4	Агаарын геофизикийн 1:200000-ны масштабын соронзон судалгааны ажлыг хэрэгжүүлэх, нутаг дэвсгэрийн 70%-ийг	2021-2024	УУХҮЯ	ҮГА	Нийт хөрөнгө: 5,406.1 2022 төсөв: 2,153.7	Ховд-2020 төслийг үргэлжүүлэх, нутаг дэвсгэрийн 68%-ийг судалгааны ажилд хамруулна.	Ховд-2020 төсөл: Өмнөх онуудад 1:200000-ны масштабын агаарын геофизикийн 5 сувгийн хэмжилтийн ажлыг 104044 кв.км талбайд явуулж агаарын хэмжилт судалгааны ажил дууссан. 2022 оны геофизикийн суурин боловсруулалтын ажлаар Нийлбэр соронзон орны эрчимжилтийн зураг, Туйлын засвар хийсэн нийлбэр соронзон орны зураг, Нийлбэр цацраг идэвхжлийн зураг (Tcnt,) Газрын калийн агуулгын зураг (K), Газрын тори-ийн агуулгын зураг (Th), Газрын ураны агуулгын зураг (U) нийт 6 төрлийн зургууд зохиох ажил хийгдсэн. 2022 оны хээрийн судалгааны ажил 05 дугаар сарын 09-нөөс эхлэн агаарын геофизикийн судалгаагаар сонирхолтой гажил гарсан хэсэгт сонгож, газрын спектрометрийн судалгаа, соронзон хайгуулын судалгаа, цахилгаан хайгуулын судалгаа, шалгалт хэмжилтийн ажил хийгдэж байна. Төслийн нийт төсвийн гүйцэтгэл 93,9 %-тай хэрэгжиж байна.	100%
		5	Геохимийн 1:1000000-ын масштабын зураг зохиох ажлыг хэрэгжүүлэх, нутаг дэвсгэрийн 100%-ийг хамруулна.	2021-2022	УУХҮЯ	ҮГА	Нийт хөрөнгө: 1,258.1 2022 төсөв: 1,157.2	Нутаг дэвсгэрийн 100%-д Геохими-2019 төслийг үргэлжүүлэх, нутаг дэвсгэрийн 80%-ийг судалгааны	Геохими-2019 төсөл: Өмнөх онуудад 540 өдөр буюу төслийн хээрийн ажлын хугацаанд сорьцлолтын 10-13 баг/отряд, нийт 7019 цэгээс геологийн даалгаврын дагуу 2 горизонтын 14038 ш сорьц, хяналтын 181 ш дээж авч төлөвлөсөн 1149529 км ² талбайг бүрхэж хээрийн үйлдэрлэлийн ажлыг явуулж дууссан. 2022 онд үр дүнгийн тайлан боловсруулалтын ажлыг орчин үеийн	100%

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
								ажилд хамруулна.	технологийг ашиглан, сорьцлолтын цэгийн мэдээллийг бодит цагийн хяналтаар баримтжуулан, тоон мэдээллийн сан үүсгэсэн. Монгол орны нутаг дэвсгэрийг 1:1 000 000 масштабтай судалгааны нэг түвшинд сорьцолсон, 14400 сорьцын архив, 7200 сорьцын шинжилгээний үр дүнгээр мэдээллийн сан үүсгэх, боловсруулалт хийх, тайлбар бичиг зохиох ажлууд хийгдэж байна. Төслийн нийт төсвийн гүйцэтгэл 96,97% -тай хэрэгжиж байна.	
		6	Бүс нутаг болон геозкологи, гидрогеологи, геотермийн судалгааны ажил хийнэ.	2021-2024	УУХҮЯ	ҮГА	Нийт хөрөнгө: 7,708.8 2022 төсөв: 1,099.4	Эрдэнэт хотын судалгааны үр дүнг хүлээн авах, Дархан, Ховд хотын судалгааг үргэлжүүлэх, Чойбалсан, Даланзадгад хотын суурьшлын бүсэд судалгааны ажлыг эхлэх, Хангайн халуун рашаан геотермийн судалгааг эхэлнэ.	“Эрдэнэт хотын геозкологи, гидрогеологийн судалгаа” төсөл Геозкологийн зураг: Геозкологийн зургийг зохиож дууссан, суурь хил заагт хамаарах тоон мэдээллийг нэгтгэн оруулах ажил хийгдэж дуусаад байна. тухайлбал ой, ургамал, хөрсний мэдээлэл, гадаргын налуу, өндөр зэргийн мэдээллийг оруулж бэлтгэсэн бөгөөд зураг тус бүрийн мэдээллийн санд атрибут хэлбэрээр бөглөгдөн орж байна. Геозкологийн зургийн нэгдсэн таних тэмдэг үүсгэсэн. Лист тус бүрээр accessaар бэлтгэсэн. Геозкологийн зургийн бүрдлийг хангах дагалдах зургууд хийгдэж мэдээллийн санд оруулсан. Геозкологийн үнэлгээний зураг: Геозкологийн үнэлгээний үзүүлэлтийг нэгтгэн гаргаж, үнэлгээний зурагт ашиглах жинлэсэн дунджийн арга зүйг ашиглаж түүнд хамаарах параметруудийг зураг хэлбэрээр бэлтгэж, 1:50 000 масштабаар бэлтгэж сэдэвчилсэн зургууд үүсгэж тэдгээрийг геозкологийн хувьд шалгуурын хүрээнд үнэлгээ хийсэн. Мэдээллийн санд оруулсан. Газар чичирхийлэлтэй холбоотой хиймэл дагуулын радарын төрлийн мэдээ ашиглан газрын гадарга дээр гарсан аливаа өөрчлөлт	100%

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
									бүхий фазын зөрүүг илтгэх зургийг төслийн талбайн хэмжээнд боловсруулсан гаргасан. Мөн үерт автах нөхцөлийг харгалзан үнэлгээний зурагт ашиглах үерийн нөхцөлийн зургийг загварчлан үүсгэсэн. Үнэлгээний зураг хийгдэж дууссан. Гидрогеологийн зураг: Гидрогеологийн зургийг 23 хавтгайн хэмжээнд зохиож, тоон системд оруулан зурж дууссан. Орхон-Чулуутын ай сав болон Сэлэнгийн ай савын газар доорхи усны химийн найрлага, чанарын талаар анализ дүгнэлт гаргасан. Өнөөдрийн байдлаар тайлангийн бичвэрийн ажил дуусаж, Улсын геологийн зургийн редакцын зөвлөлөөр хянагдаж байна. Төсөл 100% хийгдсэн. “Дархан хотын геоэкологи, гидрогеологийн судалгаа” төсөл Дөрөвдөгчийн зураг, Геоморфологийн зургийг 1:25000-ны масштабээр зурж дуусгасан. - Геоэкологи, Гидрогеологийн зургууд 1:25000-ны масштабээр 2036,41 км² талбайд зураглал хийгдсэн 2022 онд үлдсэн 569,29 км² талбайн геоэкологийн зураг, гидрогеологийн зургийг зохиохоор хээрийн үйлдвэрлэлийн ажил хийгдэж байна. 2022 оны 05 дугаар сарын 31-ний байдлаар төслийн нийт төсвийн гүйцэтгэл 66,4%-ийн гүйцэтгэлтэй, төлөвлөгөөт хугацаандаа явж байна. -Улсын төсвийн хөрөнгөөр 2022-2023 онуудад эхлүүлэх төслийн саналд “Сайншанд хотын геоэкологи гидрогеологийн судалгаа”, “Чойр геоэкологи гидрогеологийн судалгаа”-ны 2 төслийн саналыг боловсруулж, холбогдох	

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
									материал, тооцоо, судалгааны хамт Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд 2021 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 1/138 дугаар албан бичгээр илгээсэн.	
		7	Геологийн өв, тулгуур зүсэлт, онцлог тогтоц, тектоник, минерагенийн болон геохими, геофизик, энергийн түүхий эдийн хэтийн төлөвийн хэсэгчилсэн судалгааны ажил хийнэ.	2021-2024	УУХҮЯ	ҮГА	Нийт хөрөнгө: 18,000.0 2022 төсөв: 500.0	Тек-2021, ТЗ-2021 төслийг үргэлжүүлэх, энергийн түүхий эдийн төлөв /ЭТЭ-2022/ төслийг эхлүүлнэ.	Улсын төсвийн хөрөнгөөр 2022-2023 онуудад эхлүүлэх төслийн саналд “Тектоник-2021” төслийн саналыг боловсруулж, холбогдох материал, тооцоо, судалгааны хамт Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд 2021 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 1/138 тоотоор хүргүүлсэн. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас шийдвэр ирэхийг хүлээж байна. Үндэсний геологийн алба 2022 онд өндөр төнологийн түүхий эд 2 төслийг эхлүүлсэн.	100%
		8	Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, ОХУ, БНХАУ, БНСУ, БНКаЗУ зэрэг гадаад орнуудтай хамтын ажиллагааны хүрээнд геологийн судалгааны ажил хийнэ.	2021-2024	УУХҮЯ	ҮГА	Нийт хөрөнгө: 6,500.0 2022 төсөв: 300.0	ОХУ, БНХАУ, БНСУ, БНКаЗУ-тай хамтарсан геологийн судалгааны ажлын 5-р үе шатны ажлыг үргэлжүүлэх, бусад орнуудтай харилцан үр ашигтай төсөл эхлүүлнэ.	Монгол Улс, ОХУ, БНХАУ, БНСУ ба БНКаЗУ-ын хамтарсан “Хойд, төв, зүүн Азийн гүний геологийн процесс ба металлогени” төслийн V үе шат хэрэгжиж байна. /2021-2024 он/. Төсөлд хамтран оролцогч улсууд геологийн бүх төрлийн мэдээллийг нэгтгэж буй нь шинжлэх ухааны өндөр ач холбогдолтой ажил юм. Хамтран оролцогч улсуудын ажлын ээлжит уулзалтуудын хурлын протоколд үндэслэн Монгол орны нутаг дэвсгэрийн дагуу геологийн гүний тогтоцыг тодорхойлох, Төв азийн төслийн хэмжээнд хийгдсэн геологи, тектоник, ашигт малтмалуудын мэдээллийг нэгтгэн, уялдуулахад чухал ач холбогдолтой. Төслийг 3 үе шаттай явуулна. Үүнд: <u>1.Хээрийн ажил:</u> Эхний жилд: Шууд гэрээгээр. Үүнд: Монгол орны нутаг дэвсгэрт хамаарах талбайд өмнө хийгдсэн геологи,	100%

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
									тектоник, ашигт малтмалын мэдээллийг судлан нэгтгэх ажил хийгдэж байна. Хоёр дахь жилд: 2022 оны 06 дугаар сараас 09 дүгээр сарыг дуустал хэрэгжиж байна. /Талбайгаас дээж авах ажил эхэлж байна/. <u>2.Суурин боловсруулалтын ажил:</u> Завсрын суурин боловсруулалт: 2021 оны 09 дүгээр сараас 12 дугаар сарыг дуустал 2022 оны 01 дүгээр сараас 05 дугаар сарыг дуустал Эцсийн суурин боловсруулалт: 2023 оны 09 дүгээр сарын 30 хүртэл <u>3.Судалгааны ажлын үр дүн:</u> тайланд хөндлөнгийн шинжээчээр шүүмж хийлгэх, холбогдох засвар, өөрчлөлтийг хийх: 2023 оны 11 дүгээр сарын 15 хүртэл. Геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагын холбогдох нэгж, мэргэжилтнээр хянуулж, шаардлагатай засвар өөрчлөлтүүдийг хийсний үндсэн дээр Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр ирүүлэх: 2023 оны 12 дугаар сарын 31 хүртэл.	

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
2	3.2.4.Үндэсний геомэдээллийн нэгдсэн санг хөгжүүлж, цахим системийг нэвтрүүлж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлнэ.	9	Үндэсний геомэдээллийн нэгдсэн сан төслийг магматизм, стратиграф болон бусад геологийн мэдээллээр бүрдүүлэх, баяжуулах, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулна.	2021-2024	УУХҮЯ	ҮГА	Нийт хөрөнгө: 2,000.0 2022 төсөв: 500.0	Үндэсний геомэдээллийн нэгдсэн сан хөтөлбөрийн төрөлжсөн мэдээллийн сан төслийг үргэлжүүлэх, ажлын явц 60%	Улсын төсвийн хөрөнгөөр геомэдээллийн сангийн төсөл хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах УУХҮЯ/202211011 дугаартай Багц-14 буюу “Геомэдээллийн сангийн сэдэвчилсэн судалгааны үр дүнд үүссэн мэдээлэл, баримтад тулгуурлан цахим сан үүсгэх” Геологийн баримт-1-2022 нэртэйгээр ажил гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зөвлөх үйлчилгээний тендерийг 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр зөвлөх үйлчилгээний 14 дүгээр багцыг зарласан. 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдөр 14 дүгээр багцын хураангуй үүсч, Геологийн судалгааны төв, Рич серкол Монгол, BMGIS ХХК тус тус санал ирүүлж, 6 дугаар сарын 10-ны өдөр тендерийг нээсэн. Үүнээс Рич серкол Монгол ХХК нь тендерт материалаа ирүүлж, техникийн санал нь авбал зохих доод оноог авсан. 06 дугаар сарын 24-ний өдрийн 10.00 цагт санхүүгийн саналыг нээн үнэлэв. 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдөр гэрээг байгуулан, ажиллаж байна.	90%
		10	Геологийн чулуун дээжийн сан болон цахим архивыг бүрдүүлэх, баяжуулах, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулна.	2021-2024	УУХҮЯ	ҮГА	Нийт хөрөнгө: 2,000.0 2022 төсөв: 500.0	Геологийн чулуун дээжийн сан болон цахим архивыг бүрдүүлэх, баяжуулах, бүрдүүлэх төслийг үргэлжлүүлэх, ажлын явц 60%	Улсын төсвийн хөрөнгөөр геомэдээллийн сангийн төсөл хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах УУХҮЯ/202211011 дугаартай Багц-12, Багц-13 буюу Чулуун дээжийн сан-1-2022, Цахим архив-1-2022 нэртэйгээр ажил гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зөвлөх үйлчилгээний тендерийг 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр зөвлөх үйлчилгээний 12, 13 дугаар багцыг зарласан боловч хураангуй үүсээгүй учир 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдөр	100%

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
									дахин зарлал нийтэлж, 12 дугаар багцад хураангуй жагсаалт дахин үүсээгүй. Харин 13 дугаар багцад Арвин Майнинг ХХК, Эрээнчулуу ХХК, Геологийн судалгааны Төвөөс санал ирүүлж, хураангуй жагсаалт үүсэн, 06 дугаар сарын 02-ны өдөр Тендерийн урилгыг нийтэлсэн. 07 дугаар сарын 04-ний өдрийн 14.00 цагт тендерийг нээж, үнэлэв. Цахим архиваар Геологийн судалгааны төв ТӨҮГ, чулуун сангаар Арвин Майнинг ХХК шалгаран, 2022 оны 11 дүгээр сарын 30-нд тус тус гэрээг байгуулсан.	
3	3.2.5. Өндөр технологийн түүхий эд болох газрын ховор элемент, үнэт, өнгөт, хар, холимог металл, металл бус ашигт малтмал болон газрын тосны эрэл, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар эрдэс баялгийн нөөцийг арвижуул	11	Газрын ховор элемент болон өндөр технологийн түүхий эдийн суурь судалгааны ажил хийх, хэтийн төлөвийн үнэлгээ өгнө.	2021-2024	УУХҮЯ	ҮГА	Нийт хөрөнгө: 5,686.1 2022 төсөв: 564.2	ГАСАМ төслийн үр дүнгийн тайланг хүлээн авах, ГХЭ-ийн хэтийн төлөвийн судалгааг эхэлнэ.	1) ГАСАМ төслийг хэрэгжүүлэгчийн хүсэлтээр УУХҮ-ийн Сайдын 2021 оны 12 дугаар сарын 24-ний А/308 тоот тушаалаар геологийн даалгаварын хугацааг 2022 оны 1 дүгээр сарын 31 хүртэл 3 сараар сунгасан. ЭБМЗ-ийн даргын шийдвэрээр 2022 оны 07 дугаар сарын 26-ны өдөр Д.Доржготов, Ч.Гэрэлхүү нарын шинжээчдийг томилсон. 2)“Геологийн Судалгааны төв”-ийн хэрэгжүүлж буй Өндөр технологийн түүхий эд-I төслийн Нарийвчилсан эрлийн ажлаар Хатуугийн голын илрэлийн хувьд ЗХ чиглэлтэй ГХЭ болон Nb, Zr-ны сулавтар хүдэржилт бүхий аляскит маягийн боржингын сунаж тогтсон 150-350м өргөнтэй биет байх ба бидний судлаагаар хамгийн өндөр утга нь ГХЭ-0,13%, Nb-0,05%, Zr-0,17%, Y-0,08%, дундаж утга нь ГХЭ-0,03%, Nb-0,01%, Zr-0,02%, Y-0,007%, байна. Харин нарийвчилсан эрлийн Ихэрийн илрэлийн хувьд өргөрөгийн дагуу сунаж тогтсон 2-3 км хүртэл үргэлжлэх 2-3 ш дэл, судлын биет байх ба бидний шинжилгээгээр ГХЭ 0,03-1,3%, ихэнхи дээжинд Zr-0,5%-оос их, Nb 0,05-0,5% гэх мэт агуулгатайгаар гадаргадаа илэрдэг. Дэл, судлын биет тус бүр агуулга нь харилцан адилгүй байдаг ба бидний уул-	90%

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
	на.								өрөмдлөгийн ажил голлож хийгдсэн 1-р биетэд илүү өндөр агуулгатай тогтоогддог. 3)“Демон инженеринг” ХХК-ийн хэрэгжүүлж буй Өндөр технологийн түүхий эд-II Төслийн хүрээнд судалгаанд хамруулахаар одоогийн байдлаар өндөр технологийн элементүүдийг орд, илрэл, эрдэсжсэн цэгээр 1150 цэг, объект бүртгэгдсэн бөгөөд эдгээрийн мэдээллийн дэлгэрэнгүйг багтаасан 46 багана бүхий хүснэгтийг үүсгэн хээрийн судалгааны ажилд ашигласан. 2022-2023 оны завсрын суурин боловсруулалтын хугацаанд энэ санг баяжуулан илрэл, эрдэсжсэн цэгийн тоо нэмэгдэх төлөвтэй байгаа. 2022 онд явуулсан ажлын үр дүнгээр одоогоод 7 талбайг нарийвчилсан ажлын, 9 талбайг хэтийн төлөвтэй гэж үзэн ялгаад байна.	
		12	Үнэт, ховор, холимог, металл болон металл бус ашигт малтмалын нарийвчилсан эрэл, үнэлгээний ажил хийх, хэтийн төлөвийн үнэлгээ хийнэ.	2021-2024	УУХҮЯ	ҮГА	Нийт хөрөнгө: 39,325.1 2022 төсөв: 6,591.5	Үнэт, ховор, холимог, металлын чиглэлээр эрэл, үнэлгээний ажлын үргэлжүүлэх, хэтийн төлөвийн үнэлгээ хийнэ.	1)Терра сийд ХХК-ийн УТХ-өөр гүйцэтгэж байгаа Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутагт 3 хэсэг талбайд 2020-2022 онуудад гүйцэтгэсэн эрэл үнэлгээ-1 төслийн үр дүнгийн тайланд ЭБМЗ-ийн даргын шийдвэрээр 2022 оны 07 дугаар сарын 26-ны өдөр С.Мөнхбадрах, О.Ганцэцэг нарын шинжээчдийг томилсон. 2)Меланж Сурвэй ХХК-ийн хэрэгжүүлж байгаа Эрэл үнэлгээ-2 төсөл Өмнөговь болон Дорноговь аймагт 4 хэсэг талбайд геологийн судалгааны ажлыг гүйцэтгэж, суурин боловсруулалтын ажил хийгдэж байна. Судалгааны ажлын товч үр дүн: Зараа талбай. Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд, Манлай, Баян-овоо сумдын нутаг. Зараа илрэлийн хэмжээнд 4 цооног өрөмдсөн. Өрөмдлөгийн үр дүнгээс харахад калишпатжсан хувирал бүхий зарим хэсэгтээ	100%

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
									0,5-1,0мм хүртэл зузаантай, кварц-кальцитын ан цав дагасан хялгасан судлуудын бүс (зузаан нь 70м хүртэл) агуулсан гранодиорит байна. Кернийн сорьцын химийн шинжилгээгээр Cu 0.001-0.02%, Zn 0.002-0,009%, байна. Гадарга дээр малтсан сувагт эдгээр бүс 1-5м, ховроор 9-10 м хүртэл зузаантай тогтоогдсон. Бусад хэсэг дээр бага зэргийн пиритжилт бүхий бүсүүд тогтоогдсон. Номт талбай. Дорноговь аймгийн Мандах сум. Номтын илрэлийн хэмжээнд кварц-турмалины судал агуулсан малахитжсан бүсүүдэд ховилон сорьцын шинжилгээгээр Cu 0.1-0.4%, цөөн сорьцод 1-9,85%, Zn 0.03-0,04%, Au 0,01-0,05гр/тн агуулга тогтоогдсон. Өрөмдлөгийн үр дүнд 0,5-1,0м хүртэл зузаантай бага зэрэг лимонитжсан, кварцжсан, малахитын түрхэц бүхий бүсүүд тогтоогдсон. Шинээр кварц-турмалины судлын бүс (өргөн 20-30м, урт 100 м орчим) тогтоогдсон нь өрөмдлөгийн үр дүнгээр цооногт ан цав дагасан пирит, ховроор халькопиритийн хялгасан судал /0,1см хүртэл зузаантай/ маягийн эрдэсжилтүүд агуулсан 2-6, заримдаа 10м хүртэл зузаантай, кварц, кварц-турмалины судал илэрсэн. Шинжилгээний үр дүнгээр зэс 0,1-0,7%, алт 0,1-0,85г/тн хүртэл агуулга тогтоогдсон. Онгон тээг талбай. Өмнөговь аймгийн Мандал-овоо сум. Өмнөх судлаачдын ажлын үр дүнд цэглэн сорьцод зэс 0,007-0,5%, цөөн сорьцод 1% хүртэл, мөнгө 30-150гр/тн хүртэл агуулга тогтоогдсон байдаг. Бүсийн хэмжээнд баганат өрөмдлөгийн 5 цооног өрөмдсөн. Лабораторийн үр дүн хүлээгдэж байна.	

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
									Мандал талбай. Өмнөговь аймгийн Мандал-овоо сум. Олон овоотын алтны хүдрийн бүсийн үргэлжлэл гэж үзэж болох энэ талбайд Эрлийн маршрут, геофизикийн соронзон, спектрометр, цахилгаан хайгуулын ажлын үр дүнгээр эрлийн 3 хэсэг ялган, тэдгээрт төвлөрүүлэн уул-өрөмдлөгийн ажил явуулж байгаа. Агуулагч карбонат-терриген хурдас, түүнийг зүссэн риолит-порфирын дайкуудын хил заагийг дагасан хувирлын бүсүүдээс авсан цэглэн болон ховилон сорьцын шинжилгээгээр Au 0,01-0,2 гр/тн , цөөн сорьцод 2,3 гр/тн хүртэл агуулга тогтоогдсон байна. Геосигналс ХХК-ийн хэрэгжүүлж буй Эрэл үнэлгээ-3 төсөл нь Дорнод аймгийн Дашбалбар, Чулуунхороот, Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутагт 2022 хээрийн үйлдвэрлэлийн ажил явагдсан. Одоогоор Бага уулын массивын хэсэгт тогтоогдоод байгаа хүдэржилт нь тодорхой чиглэлд сунасан хэлбэр бүхий зэс-молибдений хүдэржилт бүхий порфирын төрөлд хамаарах нь тодорхой байна. Эдгээр талбайнууд дээр тогтоогдоод байгаа хүдэржилт нь гадарга дээр 0,1-0,3% Cu, 20-60 ppm Mo, 1-4 г/т Ag-ийн агуулгатай байна. Гүндээ энэ агуулга өсөх шинжтэй болох нь анхны өрөмдлөгөөс ажиглагдаж байна. Хүдэржилт ихээхэн тогтвортойгоор 10-100 м өргөн интервалуудад тогтоогдож байна. Хэдийгээр гадаргын ойр хэсэгт тогтоогдоод байгаа хүдэр нь зэс, молибден, алт, мөнгөний хувьд ядуувтар агуулгатай үйлдвэрлэлийн хүдрийн хэмжээнд байгаа боловч гүндээ агуулга нь дээшлэх магадлалтай гэж үзэж байна. 3)“Геологийн судалгааны төв”-ийн хэрэгжүүлж байгаа Эрэл үнэлгээ-4 төсөл нь	

0	1	2	3	4	5	6	7	8	9	10
									2022 онд сансрын зургийн тайлалт 673 кв.км, танилцах маршрут 80 т.км, эрлийн маршрут 55 т.км, 1: 25 000 масштабын эрэл 661,67 кв.км, 1: 10 000 масштабын эрэл 62.86 кв.км, эрэл шалгалтын маршрут 150 т.км, авто маршрут 25 т.км, хоёрдогч литогеохимийн сорьц тороор 14904ш, штуфын сорьц-75ш, цэглэн сорьц 375ш, протолочек-35, үйлдвэрлэлийн тээвэр 25500км, хүн тээвэр 14520 км, ачаа тээвэр 16540 т.км зэрэг ажлын гүйцэтгээд байна. Шинжилгээнд хамруулсан цэглэн сорьцуудаас эхний 38ш цэглэн дээжийн хариу гарсан ба эндээс үзэхэд 3 сорьцонд Au 27-33.9 г/тн агуулгатайгаар, 5 сорьцонд Au 1-7 г/тн агуулгатай гарсан үр дүнтэй байна. 4)Монполимет ХХК хэрэгжүүлж буй Баруун өмнөд монголын-Алт-2017 төсөлд ЭБМЗ-ийн даргын шийдвэрээр 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр Д.Ганболд, Д.Доржготов, С.Төмөр нарын шинжээчдийг томилсон.	
Дундаж үнэлгээ:										93,33%

2022 оны 12 дугаар сарын 15-ны өдөр

Дэлгэрэнгүй мэдээлэл авах эх сурвалж:
Дотоод хяналт шинжилгээ үнэлгээ
хариуцсан мэргэжилтэн Б.Мөнхтуяа
Холбоо барих утас: 70181208
Цахим шуудан: b.munkhtuya@ngs.gov.mn